

Муж

Судлаачид N , M хэмжээтэй тэгш өнцөгт хавтгай биет олжээ. Биетийг нэгж талтай квадратад хувааж, нэгж квадрат бүрд түүний шинж чанарыг илэрхийлэх утга оноов. Сонирхолтой нь нэгж квадрат бүрийн утга 1-ээс $\min(N, M)$ утгаас хэтрэхгүй байв. Тэгвэл уг тэгш өнцөгтөөс мөр ба багана бүрдээ 1-ээс $\min(N, M)$ хүртэлх бүх утгыг нэг нэг удаа агуулдаг квадрат муж олдох эсэхийг тодорхойлж өгнө үү.

Оролт: Эхний мөрөнд N ба M тоо сул зайгаар тусгаарлагдан өгөгдөнө. Дараагийн N мөр бүрд сул зайгаар тусгаарлагдсан M ширхэг тоог агуулах ба утга нь 1-ээс $\min(N, M)$ ийн хооронд байна.

Хязгаарлалт: $2 \leq N, M \leq 1000$

Гаралт: Олдох бол мужийн эхлэлийн элементийн дугаар болох хос тоог агуулна. Тийм муж олдохгүй бол -1 утгыг хэвлэнэ. Олон шийдтэй бол хамгийн эхэнд байрлаж буйг авна.

Жишээ:

Оролт:

3 5

1 1 2 3 3

2 2 3 1 2

3 3 1 2 1

Гаралт:

1 2

Тайлбар: 1 дүгээр мөрийн 2 дугаар элементээс эхлэн 1-ээс 3 хүртэлх тоог агуулсан 3x3 квадрат олдоно.

Оролт:

3 6

1 2 2 3 1 1

2 2 1 2 3 1

1 2 3 1 3 3

Гаралт:

-1

Тайлбар:

1 2

2 1 эсвэл

2 1

1 2 квадрат олдохгүй.